



КРЕДИТ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ББСБ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 6 сарын 22-ны өдөр

№ 2021/25

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй
хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 6 сарын 22-ны өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор Ард Санхүүгийн Нэгдэл ХК-иас Гацуурт ХХК-ийн нийт 4,400,000,000 төгрөгийн үнэ бүхий 440 ширхэг, нэг бүр нь 10,000,000 төгрөгийн үнийн дүнтэй бондыг худалдан авч, Бонд худалдах, худалдан авах гэрээ байгуулах, Андеррайтераар Ард Секюритиз УЦК ХХК-ийн сонгон ажиллуулах, Богд банк ХХК, Ард Секюритиз УЦК ХХК нартай гурвалсан гэрээ байгуулан Гацуурт ХХК-ийн 2,200,000,000 төгрөгийн бондыг буцаан худалдан авах нөхцөлтэй Репо хэлцэл хийх зөвшөөрлийг олгож, Сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж, гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах, холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал Г.Тэлмэнд үүрэг болгосугай.
3. Энэхүү санал хураалтад сонирхлын зөрчилгүй этгээдүүд оролцож шийдвэр гаргасан болохыг дурьдсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод Аудитын Хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ